



**ХЭНТИЙ АЙМГИЙН
ЖАРГАЛТХААН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 08 сарын 05 өдөр

Дугаар А/93

Жаргалтхаан сум


**Гэрээ байгуулж, санхүүжилтийн
эрх олгох тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 59 дүгээр зүйлийн 59.1.4, 59.1.5, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1, 28 дугаар зүйлийн 28.1.1, 34 дүгээр зүйлийн 34.9, 45 дугаар зүйлийн 45.5, 48 дүгээр зүйлийн 48.2.6 дахь заалтууд, заалтуудыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Тус сумын Орон нутгийн хөгжлийн сангийн 2025 оны төсвийн хөрөнгөөр хийгдэх “Малын үүлдэр угсааг сайжруулах” ажлын гэрээг 40,000,000 (дөчин сая) төгрөгөөр “Сачин-Овоо” БГБХ нөхөрлөлтэй байгуулж, санхүүжүүлэх эрх олгосугай.

2.Ажлын гүйцэтгэлийг харгалзан санхүүжилтийг олгохоор гэрээ байгуулан батлуулах, гэрээний хэрэгжилтийг хангуулж, ажлыг чанартай гүйцэтгүүлэн тайлагнаж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (С.Мөнхдэлгэр)-д үүрэг болгосугай.

ДАРГА



С.ГАНБАТ